



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН  
БАТ-ӨЛЗИЙ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2024 оны 07 сарын 05 өдөр

Дугаар А/147

Бат-Өлзий сум

**Газар эзэмших эрхийн гэрчилгээний дуудлага  
худалдаа зохион байгуулах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Газрын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1.2 дахь заалт, Засгийн газрын 2016 оны 10 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Газар өмчлүүлэх, эзэмшүүлэх, ашиглуулах дуудлага худалдаа явуулах журам”-ын 1.2, 6.1.2, 7.1 дэх хэсэг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын “Газар зохион байгуулалтын 2024 оны төлөвлөгөө батлах тухай” 2023 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 18/02 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Газар эзэмших эрхийн гэрчилгээний дуудлага худалдааны журмаар эзэмшүүлэх газрын анхны үнэ, хэмжээ байршил, зориулалтыг хавсралтаар баталсугай.

2.Дуудлага худалдаа явуулах тухай зарыг 2024 оны 07 дугаар сарын 05-ны өдрөөс эхлэн олон нийтэд зарлаж, холбогдох журмын дагуу 2024 оны 08 дугаар сарын 05-ны өдөр цахимаар дуудлага худалдааг зохион байгуулахыг газрын даамал (Д.Оюунбилэг)-д үүрэг болгосугай.


ЗАСАГ ДАРГА



С.АМГАЛАН



Сумын Засаг даргын 2024 оны  
07 дугаар сарын 05-ны өдрийн А/147  
дугаар захирамжийн хавсралт



ДУУДЛАГА ХУДАЛДААНЫ ЖУРМААР ЭЗЭМШҮҮЛЭХ ГАЗРЫН  
АНХНЫ ҮНЭ, ХЭМЖЭЭ, БАЙРШИЛ, ЗОРИУЛАЛТ

Д/д	Эзэмшүүлэх газрын байршил	Зориулалт	Газрын хэмжээ м <sup>2</sup>	Дуудлага худалдааны анх ны үнэ	Төлөвлөлтийн нэгж талбарын дугаар
	1	2	3	4	
1	4 дүгээр баг, багийн төвийн хойно	Шатахуун түгээх газар, агуулах	2000	1,600,000	3897166

---oOo---